



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 690

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4,692,582.20 (дөрвөн сая зургаан зуун ерэн хоёр мянга таван зуун наян хоёр төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Чингис хаан" музейд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга Ж.Тамир, "Чингис хаан" музейн захирал С.Чулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны ...12... дугаар сарын...27... өдрийн
 690... дугаар тогтоолын хавсралт

ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ "ЧИНГИС ХААН" МУЗЕЙД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Нийт балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өргөг (төгрөг) |
|-----------------|--------------------------------|---------------------|-------------|------------|-------------------------|---|--------------------------------|--|
| 1 | Зөөврийн тэргэнцэр | 2010.12.31 | Ш | 2 | 122,100.00 | 244,200.00 | - | 244,200.00 |
| 2 | Эвлүүлдэг тоглоом | 2010.12.31 | Ш | 2 | 1,032,330.10 | 2,064,660.20 | - | 2,064,660.20 |
| 3 | Тоглоомны суурь | 2010.12.31 | Ш | 2 | 898,070.00 | 1,796,140.00 | - | 1,796,140.00 |
| 4 | Үзмэрийн хайрцаг | 2008.12.31 | Ш | 2 | 128,791.00 | 257,582.00 | - | 257,582.00 |
| 5 | Монгол төрийн уртын дууны файл | 2013.12.31 | Ш | 1 | 330,000.00 | 330,000.00 | - | 330,000.00 |
| Нийт дүн | | | | | | 4,692,582.20 | | 4,692,582.20 |
| | | | | | | (дөрвөн сая зургаан зуун ерэн хоёр сая таван наян хоёр мянга хорин мөнгө) | | (дөрвөн сая зургаан зуун ерэн хоёр сая таван зуун наян хоёр мянга хорин мөнгө) |